**ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр гүйцэтгэх эрх мэдлийн хариуцлагыг нэмэгдүүлэх, тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлд заасан Ерөнхий сайдыг огцруулах журмыг бүхэлд нь өөрчлөн найруулж 4 хэсэгтэй байсныг 2 хэсэгтэй болгон өөрчилсөн.

Тус өөрчлөлтөөр 1992 оны Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 3, 4 дэх хэсгүүдийг хасаж, өмнөх 43.4 дэх хэсгийн "Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Засгийн газрыг огцруулах тухай саналыг албан ёсоор тавьбал Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэнэ." гэснийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн 43.1 дэх хэсэгт багтаан өөрчлөн найруулсан.

Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 2010 оны 06 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-д "*Нэгдсэн төсвийн гүйцэтгэл нь төсвийн тусгай шаардлагыг энэ хуулийн 8 дугаар зүйлд зааснаас бусад шалтгаанаар хангаагүй нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 4-т заасны дагуу Засгийн газрыг огцруулах тухай санал гаргах үндэслэл болно.*" гэж заасан. Тус заалтын Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 4-т гэсэн хэсэг өнөөдөр Үндсэн хуульд байхгүй бөгөөд тус заалтыг Үндсэн хуульд нийцүүлэн өөрчлөөгүй тохиолдолд нэгдсэн төсвийн гүйцэтгэлтэй холбогдуулан Засгийн газрыг огцруулах санал гаргах заалтыг хэрэглэх боломжгүй юм.

Улсын төсөв нь ард түмний орлого, төрийн нийтийн өмчөөс эх үүсвэртэй учир түүний гүйцэтгэлийг хянах, дүгнэх, сахилга бат алдах, хуульд заасан хязгаарлалт, зарчмыг хэрэгжүүлээгүй тохиолдолд Ерөнхий сайдад хариуцлага тооцох нь төрийн эрх барих дээд байгууллага Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хамаарах тул Улсын Их Хурал Засгийн газрыг огцруулах саналыг албан ёсоор гаргах Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хариуцлагын заалтыг практикт хэрэгжих, хэрэглэх боломжтой байхаар өөрчлөлт оруулах шаардлагатай.

Монгол Улсын Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1-д "Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино" гэж заасны дагуу Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дах хэсгийг Үндсэн хуульд нийцүүлэн өөрчлөлт оруулахаар хуулийн төсөл боловсруулаа.

Хуулийн төсөл батлагдсанаар Үндсэн хуульд бусад хууль нийцсэн байх Үндсэн хуулийн зарчим хангагдахаас гадна өөрчлөлт оруулж буй заалтын практикт хэрэгжих боломж бүрдсэнээр, Засгийн газрын хариуцлагыг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

----o0o----